





АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2019 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2019.12.20

№	Зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, Эх үүсвэр /сая төгрөг/	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)		Хувь
						Хүрэх түвшин үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	
<b>ДӨРӨВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭНД</b>								
<i>Хүнс, хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж ажиллана.</i>								
109	4.1 Мал аж ахуй, газар тариалан	4.1.1 “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатыг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.	I-IV улирал	ХХААГ	УТ 40.0	- “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хоёр дахь үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 60 хувьд хүргэнэ.	2019-2020 онд хэрэгжүүлэх 32 заалт бүхий төлөвлөгөөг ХХААГ-ын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц 92,5% хэрэгжиж байна.	100
110		4.1.2 Малчдыг мал, маллагааны арга ухаанд сургаж залуу халааг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.	I-IV улирал	ХХААГ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 186.0	- Мал цөөтэй малчдыг малжуулах болон малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж төрөл бүрийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэн дэмжсэн байна.	МСҮТ Малын асаргаа сувилгаа, мэргэжлийн малчны ангид 24 малчинг элсүүлж сургаж дадлагажуулж байна. Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран цөөн малтай иргэдийг малжуулах хөтөлбөрт хамруулж 14 сумын 40 малчинд 186 сая төгрөгөөр малжуулах ажлыг зохион байгуулаад байна. МСҮТ-тэй хамтран мал аж ахуй эрхлэлтийн сургалтад 75 залуу малчныг хамруулж мал маллагааны арга ухаанд суралцуулж мэдлэг, туршлагыг нэмэгдүүллээ. Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 48 иргэнийг хамруулж ЭМД, НДШ-д 12.2 сая төгрөгийг зарцуулаад байна. “Малчдын хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөр”-т хамрагдсан 15 залуу малчин	100

							ӨМӨЗО-ны Баяннуур аймагт “Мал ахуйн фермер”, “Туслах аж ахуйг хэрхэн хэрэгжүүлэх талаар санал солилцох” туршлага судлах арга хэмжээнд хамрагдаж мал маллах арга ухаан, туршлагад суралцаж байна.	
111		4.1.3 “Илгээлтийн эзэд” аймгийн дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.	I-IV улирал	ХХААГ		- “Илгээлтийн эзэд” ба “Залуу малчин” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.	2019 онд хэрэгжүүлэх 12 заалт бүхий төлөвлөгөөг ХХААГ-ын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна.	100
112		4.1.4 Бэлчээрийн даацад тулгуурлан мал аж ахуйг хөгжүүлэх, бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.	I-IV улирал	ХХААГ	УТ 237,7	- 40.0 га-аас доошгүй талбайд бэлчээрийн хөнөөлт мэргчид, хортон шавьжтай тэмцэх ажлыг энгийн механик болон микробиологийн аргаар малчдын оролцоотойгоор зохион байгуулна	<b>Бэлчээр хамгаалах хаврын арга хэмжээ:</b> үлийн цагаан оготнойтой 45 мян/га бэлчээрийн талбайд энгийн механик болон микробиологийн аргаар тэмцлээ. Тус аймагт зохион байгуулагдсан гамшгаас хамгаалах команд штабын улсын үзлэгийн үеэр мэргэжлийн анги албадын нийт 303 хүний бүрэлдэхүүнтэйгээр Дэрэн сумын Алаг-Өндөр багийн нутагт 25 мян/га бэлчээрийн талбайд энгийн механик аргаар, 10 сумын 20 мян/га талбайд 40 тн бактержуулсан бэлдмэл цацаж улсын төсвөөс нийт 237,7 сая төгрөгийг зарцуулан 85,0 хувийн хээрийн техникийн үр дүнтэй зохион байгуулсан. <b>Бэлчээр хамгаалах намрын арга хэмжээ:</b> Улсын төсвийн 125 сая төгрөгөөр 9 сумын 50 мян/га бэлчээрт үлийн цагаан оготнойтой энгийн механик аргаар тэмцэх ажлыг 85,3 хувийн хээрийн техникийн үр дүнтэй зохион байгуулсан. Нийт 95 мян/га бэлчээрт үлийн цагаан оготнойтой тэмцэх ажлыг улсын төсвийн 362,7 сая, орон нутгийн 1,7 сая төгрөгөөр зохион байгууллаа. Орон нутгийн 1,7 сая төгрөгөөр 43 ширхэг шувууны үүр хийсэн.	100
113		4.1.5 Тэмээний амьдын ашиг шим	I-IV улирал	ХХААГ	ОНТ 10.0	- Нутгийн шилмэл шинэ омог	Өвлийн баяр Хулд -2019 тэмээний баяр, Хотод ойрхон говь Их говийн тэмээ 2019 зэрэг тэмээний	100

		/ноос, сүү, уналгаа эдэлгээ/-ийг нэмэгдүүлж, тэмээгээ өсгөсөн сум баг малчдыг дэмжиж ажиллана.				батлуулж, Тэмээний баяр зохион байгуулна. - Тэмээ өсгөсөн малчдыг урамшуулна - Тэмээн сүргийн тоо толгойг 5 хувиар өсгөнө.	баярууд зохион байгуулж тэмээчдийн дунд олон уралдаан тэмцээн зохион байгуулж шагнаж урамшуулсан. Мөн тэмээгээ өсгөж ашиг шимийг нь нэмэгдүүлсэн Хулд сумын малчин Б.Баянжаргал, Д.Дашдооров нарыг аймгийн аварга тэмээчинээр шалгаруулан урамшуулсан. Олдохын хүрэн бор тэмээг омог болгох ажлын хүрээнд судалгааны ажил дуусч эрдэм шинжилгээний байгууллагаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон. Тэмээний тоо толгой өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар өссөн.	
114		<b>4.1.6</b> Аймгийн хэмжээнд жилдээ 10-аас доошгүй гүний худаг, 30-аас доошгүй гар худаг засварлах буюу шинээр гаргаж, бэлчээрийн усан хангамжийг тогтмол нэмэгдүүлэн хяналт тавьж, нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийг бэлчээрийн худагт суурилуулна.	I-IV улирал	ХААГ	ОНХС 55,6 Төсөл 270.0	- - Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Сайхан-Овоо сумдад гүн өрмийн 5 худаг шинээр, Сайнцагаан, Өлзийт сумдад энгийн уурхайн 10 худаг сэргээн засварлаж бэлчээрийн усан хангамжийг өмнөх оноос 2 хувиар нэмэгдүүлнэ. - Аймгийн хэмжээнд 40 цэгт уст цэгийн хайгуул хийнэ.	Төсөл хөтөлбөрийн шугамаар: •Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Дэлгэрцогт сумдад ЗЗБЭУХөгжил төслийн шугамаар 5 гүн өрмийн худаг 90 сая төгрөгөөр, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 5 суманд гүн өрмийн 5 худгийг 125 сая төгрөгөөр, ОНХС-ийн хөрөнгөөр: Өлзийт сум 1 гүн өрмийн худаг, 6 сум 30 энгийн уурхайн худгийг 55,6 сая төгрөгний зардлаар худаг засварлаж, нийт 289,6 сая төгрөгийн санхүүжилтээр бэлчээр усжуулах ажил хийгдсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 15 сумын 41 цэгт усны геофизикийн хайгуулыг тендерт шалгарсан Эрдэнэдринлинг ХХК бүрэн гүйцэтгэсэн. “Уур амьсгалд ухаалаг хандлага бий болгох нь” төслийн санхүүжилтээр Луус сумын Суврага багийн 7 малчин өрхийг бүлгийн зохион байгуулалтанд оруулж 1 гүн өрмийн худаг шинээр гарган сэргээгдэх эрчим хүчийг суурилуулан 2 га бэлчээрийн талбайд малын тэжээлийн ургамал тариалсан. Усан хангамж өмнөх оноос 1,8 хувиар нэмэгдсэн.	100
115		<b>4.1.7</b> Аймгийн хэмжээнд өндөр ашиг шимт сүүний	I-IV улирал	ХХААГ	-	- Ингэний сүүний аж ахуйг дэмжиж, өндөр	Ингэний сүү цагаан идээ боловсруулах чиглэлээр сум хөгжүүлэх сангаас Баянжаргалан, Өлзийт, Луус сумдын 4 хүнд нийт 80 сая	100

		чиглэлийн аж ахуйг хөгжүүлэн, малын тоог чанарт шилжүүлж, ашиг шим хүртээмжийг сайжруулна.				ашиг шимт малын тоог 3 хувиар нэмэгдүүлнэ.	<p>төгрөгний зээл олгосон. Ингэснээр шинэ ажлын байр 6, хадгалагдсан 2 байна.</p> <p>9-р сарын 11-13 ний өдрүүдэд Төв аймгийн Зуун мод хотноо зохион байгуулагдсан "Шилмэл мал-2019" арга хэмжээний гойд ашиг шимт мал шалгаруулах үзэсгэлэн, дуудлага худалдаа зохион байгуулагдаж, Хулд сумын Б.Батжаргалын ингэ 2-р байр, Өндөршил сумын Батбилэгийн бор гүү 1-р байр, Говь-Угтаал сумын Жаргалсайханы эм ямаанууд 1, 2-р байр эзлэн амжилттай оролцлоо. Ашиг шимт малын тоо өнгөрсөн оноос 6.8 хувиар өссөөд байна.</p>	   
116		<b>4.1.8</b> Гахай, шувууны туслах аж ахуйг хөгжүүлэх санаачилгыг дэмжинэ.	I-IV улирал	ХХААГ	-	- Гахай, тахиа, шувууны, аж ахуй эрхэлж буй аж ахуйн нэгжүүд болон шинээр 3-аас доошгүй ААН, иргэнд зээлийн дэмжлэг үзүүлж үйл ажиллагааг өргөжүүлнэ.	<p>2019 оны жилийн эцсийн байдлаар 15 өрхийн 710 тахиа, 5 өрхийн 48 гахай өсгөж байна. Энэ онд тахиа 60 толгойгоор өсч, гахай 240 толгойгоор буурсан. /2018 онд гахайн мялзан өвчин гарч устгасан./</p> <p>Туслах аж ахуй эрхлэж буй 3 иргэний үйл ажиллагааг өргөжүүлэх, туслах аж ахуй эрхлэх технологид сургах зорилгоор зах зээл бэлчээрийн удирдлага төслийн санхүүжилтээр 2 өдрийн сургалтанд хамруулсан.</p>	70

117		<p><b>4.1.9</b> Цөм сүргийн үржлийн байгууллагын үйл ажиллагааг дэмжин, нутгийн шилмэл болон гойд ашиг шимт малыг өсгөх, өөрийн аймгийн брэнд болсон омог, хэвшлийн малтай болно.</p>	I-IV улирал	ХХААГ	УТ 40.0 ОНТ 30.0	- Өндөршил сумын адуу, Сайнцагаан сумын хонь нутгийн шилмэл болон гойд ашиг шимт малыг батлуулна.	ХХААХҮЯамны сайдын 2019 оны 04 сарын 15-ны өдрийн А/108 дугаар тушаалаар Өндөршил адуунд хянан магадлагаа хийх ажлын хэсгийг, ХХААХҮЯамны сайдын 04 дүгээр сарын 04 өдрийн А/93 дугаар тушаалаар хониний хянан магадлагааны ажлын хэсэг тус тус томилогдож хувиарын дагуу хавар, намрын үзлэг ангилалтыг хийж гүйцэтгэсэн.	70
118		<p><b>4.1.10</b> ХАА-н биржийн үйл ажиллагааг тогтмол явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж, биржийн арилжааг орон нутагтаа хөгжүүлнэ.</p>	I-IV улирал	ХХААГ	-	- ХАА-н биржийн арилжааг орон нутагтаа зохион байгуулна.	<p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөө аж ахуйн бирж, Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо хамтран эрүүл ахуй чанарын шаардлага хангасан сүү цагаан идээ, хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд дундын дамжлагагүй шууд нийлүүлэх, бүтээгдэхүүнээ сурталчлан таниулах зорилгоор зохион байгуулсан “Мах, хүнсний ногоо, цагаан идээ-2019” үзэсгэлэн худалдаанд Сайнцагаан сумаас 3, Дэрэн, Адаацаг, Гурвансайхан сумын 5 үйлдвэрлэгч сүү цагаан идээ, даршилж савалсан хөмүүл, аарцтай зоодой, хүмүүлийн жүүс, хүмүүлийн хатаамал зэрэг бүтээгдэхүүнээр оролцлоо.</p> <p>Дэрэн сумын Улсын аварга саальчин Наранцэцэгийн үйлдвэрлэсэн цагаан идээ нь эрэлт ихтэй байж “Тэргүүний цагаан идээ” үйлдвэрлэгчээр шалгарсан амжилтыг үзүүллээ. Гурвансайхан, Өлзийт, Адаацаг сумдын Давших зам, Рашаантын аж богд, Амьдралын туг хоршоод нь Хөдөө аж ахуйн биржийн итгэмжлэгдсэн хоршоогоор бүртгэгдэж Хөдөө аж ахуйн гаралтай, түүхий эдийн арилжаанд 3 жил оролцох эрхтэй болсон.</p> <p>2019 онд эрх бүхий хоршоод нь хонины нэхий-4760, ямааны арьс-6420 ширхэгийг Монгол шевро ХХК-д, үхрийн шир 135, адууны шир 179 ширхэгийг Арилды ХХК-д, хонины ноос 117,8</p>	40

							тонныг бэлтгэн Могол ноос ХХК-д тус тус нийлүүлсэн байна. ХХААХҮЯ, ХААБ ТӨХХК, Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооноос хамтран 10, 11-р сард мал мах бэлтгэлийн ажлыг улсын хэмжээнд зохион байгуулахаар төлөвлөж байгаатай уялдуулан Дундговийн махны худалдааг Улаанбаатар хотод хийхээр сумдад үүрэг чиглэл өгөөд ажиллаж байна.	
119		4.1.11 Малын эмчийг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах, мал эмнэлгийн үйлчилгээг эрхлэх боломжийг бүрдүүлэн материаллаг баазыг бэхжүүлж, үйлчилгээний хүртээмж, чанар, үр нөлөөг сайжруулна.	I-IV улирал	ХХААГ	-	- Улсын мал эмнэлгийн үйл ажиллагаа жигдэрч, хувийн хэвшлийн мал эмнэлгийн нэгжийн тоог 45 хүргэж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. - Боловсон хүчний хангалтыг 70 хувьд хүргэнэ.	Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль хэрэгжиж аймагт мал эмнэлгийн газар, суманд мал эмнэлгийн тасаг байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн мал эмнэлгийн газар нь 18 орон тоотой байхаас 15, 15 суманд 30 малын эмч ажиллахаас 12 байцаагч, 3 тархвар зүйчтэй ажиллаж байна. Хуулиар тогтоосон бүтцийг бий болгон үйл ажиллагаа явуулж байгаа боловч боловсон хүчний хүрэлцээгүй байна. Мал эмнэлгийн үйлчилгээний 36 нэгжид 46 малын эмч ажиллаж байгаа ба шинээр төгссөн 5 малын их эмч Сайнцагаан, Өндөршил, Сайхан-Овоо, Дэрэн сумын мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд ажиллаж байна.	70
120		4.1.12 Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бруцеллёз өвчинтэй тэмцэх стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээг тогтмол зохион явуулна.	I-IV улирал	ХХААГ	-	- Гоц халдварт 700 мянга, халдварт 800 мянга, брцеллезоос сэргийлэх арга хэмжээнд 750 мянган мал хамруулж өвчний гаралтыг бууруулна.	Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 6 – 7 сард 13 сумын 1,3 сая, 10-р сард зүүн талын 6 сумын 1,2 сая малыг хамруулан хийсэн. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шөвөг ярын вакциныг 439,4, ДХХ-Энтеробактериозын хам вакциныг 364,9, Цусан халдвартын вакциныг 7,4, Дуут хавдарын вакциныг 6,4, галзуугийн вакциныг 27,4, боом вакциныг 2,0, бүгд 847,5 мянган малд хийж дархлаажуулсан. Бруцеллёзын вакцинжуулалтыг 15 сумын 3,4 мянган суурийн 8,2 мянган тугал, 756,3 мянган богийн төлийг хамруулсан хийсэн. Гоц халдварт өвчин гараагүй.	70

121		4.1.13 Мал эмнэлэг ариун цэврийн лабораторийн оношилгооны чадавхыг үнэлэх магадлан итгэмжлэлийн зардал, халаалт дулааны сүлжээний асуудлыг шийдвэрлэж ажиллах нөхцөлийг дээшлүүлнэ.	I-IV улирал		-	- Хөдөлгөөнт лабораторийн гражийг шийдвэрлэж хамгаалалт ашиглалт сайжирна. - Халаалтын сүлжээг шинэчилж дуусгана.	Мал эмнэлгийн лабораторийн магадлан итгэмжлэлийг сунгуулахаар хүсэлтийг 2019 оны 09 дүгээр сард Стандарт хэмжилзүйн газарт хүрүүлсэн. Итгэмжлэлд ороход шаардагдах бичиг баримт, Чанарын гарын авлага-1, лабораторийн журам-18, стандарт-30, арга зүй-14 тус бүр боловсруулсан. 12 сард багтаж итгэмжлэлийг сунгуулна. Лабораторийн халаалт, дулааны сүлжээг 2017 онд хэсэгчлэн солисон. Хөдөлгөөнт лабораторийн гражийг барих материалыг бүрдүүлээд байна. 11 сард багтаж хийгдэнэ. 2019 оны 9 дүгээр сард АНУ-ын Канзасын их сургуулийн судлаачидтай хамтран Өлзийт сумын Буянт багт 3 хоног хөдөлгөөнт лабораторийг ашиглав. Үүнд: Тэмээний шүлхийн халдвар байгаа эсэхийг тандах шинжилгээ, дундад Азийн амьсгалийн замын хам шинжийн коронавирус илрүүлэх тандан судалгааг хийж гүйцэтгэв. Нийт 100 тэмээнээс цус болон хамрын арчдасын сорьц авч газар дээр нь шинжилж үр дүнг үнэлэв, шүлхийн эерэг дээж илрээгүй. Мал эмнэлгийн лабораторийн чадавхийг сайжруулах зорилгоор 13 төрлийн өвчин оношлох молекул биологийн арга зүйн оношлуур хэрэглэгдэхүүнийг гадаад хамтын ажиллагааны шугамаар хүлээж аваад ашиглаж байна.	70
122		4.1.14 Дэрэн суманд байгуулагдсан тэжээлийн ургамал тариалах ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг өргөжүүлж, аймгийн тэжээлийн үрийн хэрэгцээг хангана.	I-IV улирал	ХХААГ	УТ 5.0	- Дэрэн суманд байгуулагдсан тэжээлийн ургамал тариалах ОНӨААТҮГ-ын түр зогссон үйл ажиллагааг эхлүүлнэ.	Энэ оны байдлаар 0,1 га-гаас 1 тн тэжээлийн ургамал хураан авч үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. 2019 оны 5 сарын 25-ны өдөр БОАЖЯам, аймгийн ЗДТГ, Орчныг бохирдуулах үндэсний хороо хамтран Дэрэн сумын ЭШТӨҮГ-ын тэжээлийн ургамлын талбайд “Хөрс хамгаалалт” талбайн үзүүлэх сургууль, хэлэлцүүлгийг 100 гаруй эрдэм шинжилгээний ажилтнуудыг оролцуулан зохион байгуулсан.	100
123		4.1.15 Онги голыг түшиглэн усалгаатай	I-IV улирал	ХХААГ	Хувийн хэвшил	- Төмсний хэрэгцээг 11	Сайхан-Овоо сум 2019 онд төмс 5,3 га-гаас 59,5 тн, хүнсний ногоо 1,9 га-гаас 19,5тн, чацаргана	70


		газар тариалангийн /төмс, хүнсний ногоо, чацаргана/ аж ахуй байгуулахыг дэмжинэ.			20.0	хувь, хүнсний ногооний хэрэгцээг 6.5 хувь, чацаргана 1.2 хувь хангана.	8,5 га-гаас 5,1тн тус тус хураан авсан байна. 2018 онтой харьцуулахад хураан авсан ургацын хэмжээ 43,8 тн-оор өссөн байна. Төмсний хэрэгцээг 23 хувь, хүнсний ногооны хэрэгцээг 3.4 хувь, чацарганы хэрэгцээг 1.2 хувиар хангаж байна.	
124		<b>4.1.16</b> Өвлийн нарлаг хүлэмжийг байнгын ажиллагаанд оруулж, иргэд, байгууллага, аж ахуй нэгжийн хүнсний нарийн ногоо, жимс жимсгэний тариалалтыг дэмжинэ.	I-IV улирал	ХХААГ	Хувийн хэвшил 20.0	- Хүлэмжийн талбайг 5 га-аар, ургацыг 10 тн-оор тус тус нэмэгдүүлнэ.	Өвлийн хүлэмжинд 0,148 га /1473 м2/ талбайд тариалсан, талбайн хэмжээ урьд оноос 0,0273га /273 м2/-аар нэмэгдсэн. Хураан авсан ургац урьд оноос 3,3 тн-оор нэмэгдсэн байна. Аймгийн хэмжээнд хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийн хүлэмжийн тоо 71 ш ба тариалсан талбай 0,9га-д 44 тн хураан авч, тариалсан талбай хэмжээ урьд онтой харьцуулахад 0,117га-аар нэмэгдэж, хураан авсан ургацын хэмжээ 10 тн-оор өссөн.	70
125		<b>4.2.1</b> Хөнгөн, жижиг, дунд үйлдвэрийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах тогтолцоог хөгжүүлж “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөр хэрэгжүүлнэ.	I-IV улирал	ХХААГ	-	- Судалгааны хэрэгцээнд үндэслэн үе шаттайгаар мэргэжилтэй ажилтныг сурган бэлтгэсэн байна.	“Хөгжлийн хөтөч” ТББ-тай хамтран 80 иргэнд төсөл боловсруулах арга зүй, Хариуцлагатай, тогтвортой нийгэм” төслийн хүрээнд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл” 10 өдрийн сургалтанд шинээр бизнес эхлэхээр төлөвлөсөн болон өргөжүүлэх зорилготой 8 иргэн суралцан бизнесээ эхлүүлж, хөгжүүлэхэд шаардагдах бүхий л мэдлэг чадвар техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах арга зүйд суралцлаа. Энэ онд нийт 88 иргэнийг сургалтанд хамруулсан. Сайнцагаан сумын ЗДТГ-тай хамтран Сайнцагаан суманд гутал засварын үйлчилгээ үзүүлж буй 12 иргэний хэрэгцээг тодорхойлох хэлэлцүүлэг зохион байгууллаа. Гутал үйлдвэрлэгч иргэдэд гутлын загварыг сайжруулах, ажиллах орчныг сайжруулах, материал сонголтын талаар зөвлөгөө авах зайлшгүй хэрэгцээ байна. Иймд Герман улсаас ахмад зөвлөх мэргэжилтнийг урилгаар ажиллуулах хүсэлтийг ХБНГУ-н SES байгууллагад хүргүүлснээр ХБНГУ-н SES байгууллагаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ны	100



							өдөр Дундговь аймагт хүрэлцэн ирж гутал үйлдвэрлэгч иргэдэд технологи, чанар сайжруулах сургалт зохион байгуулахаар төлөвлөөд байна.	
126	4.2 Үйлдвэрлэл үйлчилгээ, хүнс худалдаа	4.2.2 “Дундговийн мах”, “Дундговийн айраг” брэндийг баталгаажуулж, экспортыг дэмжиж, Улаанбаатар хотод худалдааны цэгтэй болно.	I-IV улирал	ХХААГ	СХСан 80.0	- Орон нутгийн нөөц баялагийг зүй зохистой ашиглан Дундговийн мах, айраг брэндийг хэрэглэгчдэд сурталчлах таниулах зорилгоор Улаанбаатар хотод махны худалдааны цэгийг нээн үйл ажиллагааг жигдрүүлсэн байна.	“Их хайрхан мандал” ХХК нь Нисэх, Яармагт мах худалдан борлуулах салбарыг нээж Улаанбаатар хотын хэрэглэгчдэд Дундговийн махыг тасралтгүй нийлүүлж байна. Мөн Сайнцагаан сумын иргэн Т.Болортуяа шинээр махны худалдааны бөөний төвийг нээн ажиллуулж Улаанбатаар хотын зах зээлд 110 тн, Өмнөговийн зах зээлд 200 гаруй тн махыг тус тус бэлтгэн нийлүүлээд байна. Сайнцагаан сумын “Буянт өртөө” ХХК, Эрдэнэдалай сумын “Цагаан далай” ХХК-иуд сум хөгжүүлэх сангаас олгосон 80,0 сая төгрөгийн дэмжлэгтэйгээр “Мах ангилах хатаах үйлдвэр”-ийг ашиглалтанд оруулж мах шулагч, зөөгч, үйлчлэгч зэрэг 7 орон тоог шинээр бий болгосон байна. Үйлдвэр нь борц хатаагч, вакумжуулагч, махны хөрөө, бандан, номераторын машин зэрэг тоног төхөөрөмжүүдийг суурилуулснаар 2018, 2019 онд тэмээ, үхрийн 15 тн махыг шулж борцлон хатааж зах зээлд нийлүүлжээ.	70
127		4.2.3 Сум бүр мал нядалгааны цэгтэй болж улмаар хүнсний захуудад орон тооны малын эмчийг тогтмол ажиллуулан эрүүл ахуйн шаардлагад нийцсэн махаар хүн амын хэрэгцээг тасралтгүй хангана.	I-IV улирал	ХХААГ	-	- Хүнсний захад малын эмчийг тогтмол ажиллуулж малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний гарал үүслийг нь гэрчлэх мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, шинжилгээний	Аймгийн хэмжээнд 2198 өрхийн адуу-534, үхэр-169, тэмээ-145, хонь-8087, ямаа-4005, нийт-12940 амьд мал, адууны мах-85.3тн, үхрийн мах-45.8тн, тэмээний мах 55.1тн, хонины мах-220.8тн, ямааны мах-81тн, нийт-488 тн мах, дайвар бүтээгдэхүүн-3.8 тн, адууны шир-53ш, үхрийн шир-28ш, хонины арьс-922ш, ямааны арьс-1953ш, сүү-75л, хоормог-190л, ноос-1194.5тн, ноолуур-2.1тн мал амьтны гаралтай бүтээгдэхүүнд мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ олгож мал амьтны гаралтай түүхий бүтээгдэхүүнд хяналт тавьж ажиллаж байна. Аймгийн төвийн сургууль, цэцэрлэгийн хүнсний	70

						бичиг, дүгнэлттэй худалдаа үйлчилгээ эрхлэлтийн эзлэх хувийг 50-аас доошгүй хувьд хүргэнэ.	бүтээгдэхүүн, зах дээр худалдан борлуулж байгаа мал амьтны гаралтай түүхий бүтээгдэхүүнд шинжилгээ тогтмол хийж ажиллаж байна.	
128		<b>4.2.4</b> Аймгийн хэмжээнд нийтийн хоол, зочид буудал болон бусад үйлчилгээний чиглэлээр орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн үйлчилгээний төвийг байгуулах санаачилгыг дэмжинэ.	I-IV улирал	ХХААГ	Төсөл хөтөлбөр 800.0	- Нийтийн хоол, зочид буудал болон бусад үйлчилгээний чиглэлээр орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн үйлчилгээний төвийг байгуулах аж ахуйн нэгжид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана	Зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагаа явуулдаг "Дэлгэрэх бүрд" ХХК нь 800 сая төгрөгийн санхүүжилтээр орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн нэг ээлжинд 27 зочин хүлээж авах хүчин чадал бүхий Зочид буудал, 120-150 хүн хүлээн авах Зоогийн газар бүхий үйлчилгээний шинэ төвийг нээн ажиллуулж шинээр 15 ажлын байрыг нэмэгдүүлэн ажиллаж байна.	100
129		<b>4.2.5</b> Хоол, хүнс үйлдвэрлэл үйлчилгээний ажилтнуудын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	I-IV улирал	ХХААГ	-	- Мэргэжлийн сургалт, арга зүй, техник, технологи нэвтрүүлэхэд нь санхүүгийн хөнгөлөлт, төсөл бичих сургалтад 150-иас доошгүй ажилчдыг хамруулсан байна.	"Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье" жилийн ажлын хүрээнд хүнс үйлдвэрлэгчид, төсөвт байгууллагын удирдлага, тогооч 50 гаруй хүнийг хамруулан сургалт зохион байгууллаа. Уг сургалтаар Монголын тогооч нарын холбооны тэргүүн доктор профессор С.Нарангэрэл "Давсны хэрэглээг бууруулах стратеги", "Давсыг хэрхэн зөв зохистой хэрэглэж хэвших", "Хоолны технологийн карт хөтлөлт, шимт бодис илчлэгийг хэрхэн тооцох" талаар мэдлэг олгосноор давсны агууламжийг бууруулах төрөл бүрийн зөвлөгөө, мэдээлэл авч, шинэ жор, технологид суралцснаар хоол	100

						- Дундговь аймгийн Монгол улсын Мастер тогоочдын нэрэмжит өдөрлөгийг зохион байгуулж хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарынхны мэргэжил ур чадвар дээшлүүлэх сургалт, урлаг, спорт, ажил мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулна.	үйлдвэрлэгч байгууллагын хоолны цэсэнд 2-3 нэр төрлийн хоол шинээр оруулж сурталчлах түгээн дэлгэрүүлэх боломжийг бүрдүүллээ. 11 дүгээр сарын 12-ны өдөр МСҮТ-ийн тогооч мэргэжлийн ангийн сурагчдын дунд ур чадварын уралдааныг зохион байгуулж нийт 17 оюутан оролцож ур чадвараа сорьлоо. Мөн хоол үйлдвэрлэл үйлчилгээний чанар стандартын хэрэгжилт, бодлого зорилтын талаар мэдээлэл зөвлөгөө, зөвлөмж өглөө.	
130		<b>4.2.6</b> Аймгийн төвд стандартын шаардлага хангасан худалдааны төв байгуулж, хүнсний бүтээгдэхүүнд хяналт үнэлгээ хийх дотоодын лабораторитой болж эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр иргэдийг хангана.	I-IV улирал	ХХААГ		- Стандартын шаардлага хангасан худалдааны төв, дотоодын хяналтын лаборатори байгуулах санал санаачилгыг дэмжинэ.	Стандартын шаардлага хангасан хэрэглэгчдийн тав тухтай үйлчлүүлэх орчин нөхцөл бүхий шинээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн худалдааны төвүүд болох “Тогоогийн Говь” ХХК-ны “Жавхлан”, “Номадс фүүд” ХХК-ны “Дэлгэрхангай плаза”, “Аргил трейд” ХХК-ны “Энза маркет” худалдааны төвүүд нь Стандарт хэмжил зүйн хэлтсээр Стандартын тохиролын үнэлгээ, Мэргэжлийн хяналтын газрын Сорилтын лабораториор хүнсний бүтээгдэхүүний дээжинд шинжилгээ хийлгэж эрүүл ахуйн шаардлага нийцсэн хүнсний бүтээгдэхүүнийг хүн амын хэрэгцээнд нийлүүлэн ажиллаж байна.	100
131		<b>4.2.7</b> Ажлын байр шинээр бий болгосон, шинэ нэр төрлийн үйлдвэрлэл үйлчилгээ	I-IV улирал	ХХААГ	-	- Ажлын байр шинээр бий болгосон, шинэ нэр төрлийн	Сум хөгжүүлэх сангаас Цагаандэлгэр, Эрдэнэдалай, Баянжаргалан, Гурвансайхан, Сайнцагаан, Өндөршил, Говь-Угтаал, Өлзийт, Луус, Сайхан-Овоо, Дэлгэрцогт, Дэрэн сумд 56	100

		нээсэн, бүтээгдэхүүнээ гадаад дотоодын зах зээлд нийлүүлж буй бизнес эрхлэгчдийг дэмжинэ.				<p>үйлдвэрлэл үйлчилгээний газар, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, борлуулалтын орлого өссөн байна.</p> 	
132		<p><b>4.2.8</b> Дундговьд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг БНХАУ-ын Эрээн хот, ОХУ-ын Эрхүү хотуудад борлуулах сурталчлахад дэмжлэг үзүүлнэ.</p>	I-IV улирал	ХХААГ	-	<p>- Орон нутгийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг Эрээн хотод зохион байгуулах үзэсгэлэн худалдаанд оролцуулах арга хэмжээ авна.</p> <p>6 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Баяннуур аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийн төлөөлөлийг урьж харилцан туршлага солилцох мэдээлэл түгээх замаар үйлдвэрлэл эрхлэгчдийн бодит орлого, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, хөгжүүлэх талаар санал бодлоо солилцож, зөвлөгөөн үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.</p> <p>Монгол Хятадын – EXPO үзэсгэлэн худалдаанд Дундговь аймгийн Сайнцагаан сумын Цагаан арвай бүлгийн гишүүн А.Будсүрэн цагаан эсгийгээр хийсэн 4 нэр төрлийн гар урлалын бүтээгдэхүүнээр амжилттай оролцож 1,5 сая төгрөгний борлуулалтын орлоготой ажилласан байна. Цаашид Өвөрмонгол улсын бэлэг дурсгал үйлдвэрлэгчтэй түншлэл тогтоож бараа бүтээгдэхүүнээ гаргах боломж нээгдэж байна.</p>	100

									
133		<p><b>4.2.10</b> Орон нутгийн хөрсөнд ургасан хөмүүлийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах үйлдвэр, цех байгуулж хүн амыг экологийн цэвэр хүнсээр хангах санаачлага гаргасан үйлдвэрлэгчийг дэмжиж ажиллана.</p>	I-IV улирал	ХХААГ	СХС 11.0	<p>- Хөмүүлийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулан, савлах санал санаачилгыг дэмжинэ.</p>	<p>Гурвансайхан сумын “Уул хадарганатай” өрхийн үйлдвэрлэл, Дэлгэрхангай сумын иргэн Д.Даваа хөмүүл боловсруулж савлахаар СХС-аас зээл авч үйл ажиллагаа эрхэлж байна. Дээрх үйлдвэрлэгчид ХХААХҮЯамнаас жил бүр зохион байгуулдаг “Намрын ногоон өдрүүд-2019” арга хэмжээнд даршилж савалсан хөмүүл, аарцтай зоодой, хүмүүлийн жүүс, хүмүүлийн хатаамал, Сайнцагаан, Дэрэн, Дэлгэрцогт сумын 4 иргэн 1300 орчим гар аргаар даршилж савалсан хөмүүл бэлтгэн оролцсон.</p>		100
<b>Нийт арга хэмжээ-25. Үүнээс 100 хувьтай 15, 70 хувьтай 9, 40 хувьтай 1</b>									
<b>86,8</b>									

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭСЭН: МЭРГЭЖИЛТЭН

Ю.ГАНЦЭЦЭГ

ХЯНАСАН: ХХААГ-ЫН ДАРГА

Б.МӨНХЖАРГАЛ